

Засаг даргын 2020 оны 09
сарын 01 -ний өдрийн 1184
тоот захирамжийн хавсралт

Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Даваасүрэн	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	Д.Сарангэрэл	(ХААТ-ийн мэргэжилтэн)
Гишүүд:	Н.Ганбат	(Санхүү албаны дарга)
	А.Бямбадорж	(МЭ-ын улсын байцаагч)
	Ц.Мөнхсайхан	(Ус цаг уур орчны төвийн эрхлэгч)
	Б.Өлзийбат	(Улсын нөөцийн нярав)
	Б.Гүнсэнтүг	(1-р багийн засаг дарга)
	М.Амарзаяа	(2-р багийн засаг дарга)

Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Даваасүрэн	(Засаг даргын орлогч)
Нарийн бичгийн дарга:	П.Отгонжаргал	(Цэцэрлэгийн эрхлэгч)
Гишүүд:	Н.Долгорсүрэн	(СЭ-ийн эрхлэгч)
	Т.Уранчимэг	(Сургуулийн захирал)
	Э.Ванчиндорж	(Хэсгийн төлөөлөгч)
	М.Ганбуд	(Соёлын төвийн эрхлэгч)
	Д.Билгүүн	(Ган-Илч ХХК-ийн эрхлэгч)
	М.Найдан	(БЗӨБЦТСТӨХК)
	Ц.Мөнхсайхан	(Ус цаг уур өртөөний техникч)
	Б.Өлзийбат	(Улсын нөөцийн нярав)
	Л.Батбаатар	(4-р багийн засаг дарга)

ЗАСАГ ДАРГА **БАТЛАВ** Т.АРИУНАА

2023 оны 09 сарын 01

ГОВЬ-УГТААЛ СУМЫН 2023-2024 ОНЫ МАЛ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
Нэг. Хөдөө аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах зохион байгуулалтын ажил:			
1.1	ЗГ-ын 2023 оны ... дүгээр тогтоол, Аймгийн засаг даргын 2024 оны ... албан даалгаварыг хэрэгжүүлэн ажиллах	9,10 сард	Ажлын хэсэг
1.2	Хөдөө аж ахуй болон төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах	8 сард	Ажлын хэсэг
1.3	Өвөлжилтийн албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, нэгдсэн төлөвлөгөө гаргах, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын явцад хяналт тавих	9,10 сард	Засаг Дарга
Хоёр: МАА-н бэлгэл ажил хангах			
2.1	Аюулгүй нөөцийг бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүжилтыг эртнээс төсөвлөн бүрдүүлсэн байх	9-р сард	Засаг Дарга
2.2	Малын чанар, сүргийн бүтцийн зохистой харьцаанд тулгуурлан малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, бог малын хээлтүүлэгчийг ялган суурилах, чанартайхээлтүүлэгчийг үржилд ашиглах, хээлтүүлэгт орох хээлтэгчийн тоог намаржилтын байдал, малын тарга хүч, ирэх өвөл хаврын цаг агаарын урьдчилсан төлөв байдлыг тооцон тохируулахад чиглэл өгч мэдээллээр ханган ажиллах	9-р сард	ХААТ-ийн мэргэжилтэн, БЗД нар
2.3	Бэлчээрийн ургамлын гарц, байдлыг газар дээр нь үзэж, даац багтаамж бэлчээрийн ургац, намаржилтын байдлыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээр, нутгийг хамгаалалтад авах, малын хөлөөс чөлөөлөх арга хэмжээ авах	10 сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.4	Засгийн газрын 2023 оны 279 дүгээр тогтоолын дагуу байгалийн өвс хадлан, гар тэжээл хужир шүү бэлтгэх, сумын аюулгүйн нөөцөд 40тн өвс, 30тн тэжээл бэлтгэж нөөцлөх, татан авах зэрэг ажлыг сум орон нутгийн хэмжээнд өргөн хүрээтэй зохион байгуулах, түншийн холбооны байгууллагуудын туслалцаа дэмжлэг авах, аюулгүйн нөөцийг өөртөө бүрдүүлэх, өнгөрсөн жилд бэлтгэсэн нөөцийн өвс тэжээлийн	9 сард	Сумын засаг дарга, Ажлын хэсэг

	үлдэгдлийн чанао хадгалалтын байдлыг харгалзан зарцуулах		
2.5	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр шинээр гаргаж, засварлаж байгаа худгийн ажлыг хугацаанд нь технологийн дагуу чанартай гүйцэтгүүлэн 10 сарын 30-ны дотор хүлээн авах	10 сард	Сумын засаг дарга, Ажлын хэсэг
2.6	Малын гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчнийн вакцинжуулалт хийгдэж дуусах хугацаанд болон цаашид малчдын отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хатуу хяналт тавих, сэжигтэй мал амьтныг нэвтрүүлэхгүй байх арга хэмжээг сум орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх	8-11 сард	МЭТ МЭНэгж БЗД
2.7	Өөр аймаг, сумын нутагт оторлож байгаа малчин өрхийг орон нутгийн захиргааны байгууллага болон хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагын тусламж үйлчилгээ үзүүлж ажиллах	8-10сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.8	Малчин өрх бүрд өвөлжилт, хаваржилтын бэлтгэлээ хангах чиглэлээр заавар зөвлөмж өгөх, үүрэн холбооны тархалтыг сайжруулах, өрх бүрд цаг агаарын мэдээ хүргэх, цаг үеийн мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх	8-10сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.9	Аймаг дундын орын бүс нутгууд болон отор ихээр орсон аймаг сумдад отроор өвөлжиж, хаваржих өрх, малын тоог нарийвчлан гаргаж холбогдох аймаг сумдын удирдлагуудтай гэрээ байгуулан малчдыг ая тухтай оторлуулах нөхцөлийг хангаж ажиллах	8-10сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.10	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсгийг багуудад газар дээр нь ажиллуулж өвөлжилтийн бэлтгэлийг хүлээн авах	8-10сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.11	Гарал үүслийн гэрчилгээтэй, стандартын шаардлага хангасан өвс, тэжээлээр аюулгүй нөөцийг бүрдүүлж, шаардлага хангасан агуулахад стандартын дагуу хадгалах	8-12сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.12	Аюулгүй нөөцийн өвс тэжээл хадгалах агуулахыг засаж сайжруулан бороо цас, шороо, хортон шавж, мэргч, гадны амьтад нэвтэрч орох боломжгүй болгох	8-10сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.13	Сумдын өвөлжилт хариуцсан мэргэжилтэн, багийн Засаг дарга нарын амралтыг зохицуулж, хөдөө малчдын дунд ажиллуулан, бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн нормыг хангуулахад болон хугацаатай мэдээ судалгааны үнэн, бодит байдал, чанарт анхаарах	8-10сард	Сумын засаг дарга, БЗД нар
2.14	ЗГ-ын 279 дүгээр тогтоолын дагуу өвөлжилтийн бэлтгэх хангах талаар зохион байгуулж буй ажлын явц, хадлан, гар тэжээл бэлтгэлийн мэдээг 7 хоног бүрийн Лхагва гаригт аймгийн ХХААГ-ын МАА албанд ирүүлэх, ирүүлээгүй тохиолдолд тухайн ажил хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах	8-11сард	ХААТ-ийн мэргэжилтэн
2.15	Зөвлөмжийн талаар зохион байгуулсан ажлын тухай илтгэх хуудас, ХХААХҮЯ-ны сайдын 2016 оны 05		

	сарын 10-ны өдрийн А/71 тушаалаар батлагдсан "Мал өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах, шалгах дүгнэх заавар"-ын дагуу өвөлжилтийн бэлтгэл хангах талаар гарсан шат, шатны байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг сумын Засаг даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамт 10 сарын 10-ны дотор ХХААГ-т хүргүүлэх		
Гурав. Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах талаар:			
3.1	Улсын төсөв, ОНХСан, бусад төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажилд хяналт тавьж, цаг хугацаанд нь хүлээн авах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	Сумын засаг дарга, Ажлын хэсгийн ахлагч
3.2	Дотуур байрны халаалт, дулаан, эрүүл ахуй, халдваргүйтэл, хоол хүнсний бэлэн байдлыг хангаж, аймаг сум дамжин оторт гарах малчдын хүүхдүүдийг дотуур байранд эхний ээлжинд бүрэн хамруулах	09.01-06.01	ЕБСургуулийн захирал, Нийгмийн ажилтан
3.3	Сургууль, Цэцэрлэг, Дотуур байрны барилга байгууламж, ариун цэврийн халдвар дэглэмийн бэлэн байдлыг хангаж үйл ажиллагааг 9 сарын 01-ээс эхлүүлэх	8,9 сард	БСургуулийн захирал, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
3.4	Отор нүүдлээр яваа нийт хүн ам болон эрсдэлт бүлгийн иргэдийн судалгааг гаргаж, иргэдийн эрүүл мэндэд хяналт тавьж, шаардлагатай эм, эмнэлэгийн тусламжийг үзүүлж ажиллах	Тухай бүр	Сумын эмнэлэг, Багийн эмч нар, Эм эргэлтийн сан
3.5	Томуу, томуу туст өвчин, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх сургалт суртчилгааг эрчимжүүлэн зохион байгуулах	3,4-р улиралд	Сумын эмнэлэг
3.6	Болзошгүй эрсдэл, томуу, томуу туст өвчин, коронавируст халдварын үеийн бэлэн байдалд шаардагдах тусгаарлах байр хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг нэмэгдүүлэх, сумын эрүүл мэндийн төвийн машин, техник, эм эмнэлэгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангах	3,4-р улиралд	Сумын эмнэлэг, Багийн эмч нар
3.7	Гудамж хороолол талбайн гэрэлтүүлэг засвар үйлчилгээ хийж, цагийн тохиргоог шинэчлэх	Сар бүр	ЗДТГазар, Багийн дарга
3.8	Сумын цахилгаан дулааны найдвартай байдлыг хангаж ажиллах	Тухай бүр	Ажлын хэсэг Эрчим хүчний салбар
3.9	Төв суурин газрын бэлтгэл ажлыг 9 сарын 20-ны дотор ажлын хэсгийн даргад тайлагнах	9 сард	Байгууллагын дарга эрхлэгч нар
3.10	Болзошгүй гамшгийн үед дулааны шугам, холбоо харилцаа, мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах	Тухай бүр	Эрчим хүчний салбар, Цахилгаан

			холбоо, Ган-Илч ХХК
3.11	Эзэнгүй нохой устгах	9,11-р сард	ЗДТГ, БЗДарга
3.12	Төсөвт байгууллага аж ахуйн нэгжийн дулааны болон цэвэр, бохир усны худгын амыг дулаалах, дээвэр цонх хаалганы дулаалгыг хийлгэх	8-9-р сард	АБДарга эрхлэгч нар БЗДарга

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН
 ХААТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН /Д.САРАНГЭРЭЛ/